



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2018 оны 11 сарын 06 өдөр

Дугаар А/454

Улаанбаатар хот

Г

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 17.10.5, 17.11.4, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, 16.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам"-ыг нэгдүгээр, "Сонгон шалгаруулалтын үнэлгээ хийх заавар"-ыг хоёрдугаар, сонгон шалгаруулалтын дүнгийн хуудсыг гуравдугаар, шалгалтын нэгдсэн үнэлгээний хуудсыг дөрөвдүгээр, тоеис шалгалтын оноог бусад шалгалтын оноотой харьцуулсан хүснэгтийг тавдугаар, тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, бүрдүүлсэн материалын баталгааг илэрхийлсэн өргөдлийн хуудсыг зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг энэхүү тушаалын хавсралтаар баталсан журмыг баримтлан сонгон шалгаруулж, томилохыг Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгосугай.

3. Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулахад шаардагдах зардлыг холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлэхийг эмнэлгийн дарга, захирал нарт зөвшөөрсүгэй.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Э.Содномжамц/-д даалгасугай.

САЙД

Д.САРАНГЭРЭЛ



081784

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 11 дүгээр сарын 06.
өдрийн тухай тоот тушаалын
нэгдүгээр хавсралт

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЭМНЭЛЭГ, НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг энэ журмыг баримтлан нээлттэй сонгон шалгаруулна.

Нэг. Нээлттэй сонгон шалгаруулалтын зарыг мэдээлэх

- 1.1 Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь эмнэлгийн захирлын сонгон шалгаруулалт явуулахаас 21-ээс доошгүй хоногийн өмнө хэвлэл, мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлана. Энэхүү зарыг Эрүүл мэндийн яамны болон Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газрын цахим хуудсанд байрлуулна.
- 1.2 Зар нь эмнэлгийн захирлын ажлын байранд тавигдах шаардлага, бурдүүлэх материал, сонгон шалгаруулалт явуулах газрын хаяг, материал хүлээн авах, бүртгэл явагдах хугацаа, хариуцах ажилтны утасны дугаарын мэдээллийг агуулсан байна.

Хоёр. Сонгон шалгаруулалтын үе шат

- 2.1 Эмнэлгийн захирлын албан тушаалд ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагааг Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл зохион байгуулна. Төлөөлөн удирдах зөвлөлийн орон тооны ажилтан нь саналын эрхгүйгээр сонгон шалгаруулах үйл ажиллагааны нарийн бичгийн даргаар ажиллана.
- 2.2 Сонгон шалгаруулалттай холбоотой аливаа асуудлыг төлөөлөн удирдах зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэнэ.
- 2.3 Төлөөлөн удирдах зөвлөл нь сонгон шалгаруулалтыг 3 үе шаттайгаар зохион байгуулна.
 - 2.3.1 Нэгдүгээр шат буюу Материал хүлээн авч, баримт бичгийн үнэлгээ хийх
 - 2.3.2 Хоёрдугаар шат буюу Ур чадварын үнэлгээ хийх
 - 2.3.3 Гуравдугаар шат буюу Шалгарсан нэр дэвшигчийг эмнэлгийн захирлаар томилох

Гурав. Материал хүлээн авч, баримт бичгийн үнэлгээ хийх

- 3.1 Шалгаруулалтад оролцохыг хүссэн иргэнээс дор дурдсан баримт бичгийг тогтоосон хугацаанд хүлээн авч бүртгэнэ.
 - 3.1.1 Төрийн албан хаагчийн анкет (Төрийн албан хаагчийн биеийн байцаалтын маягт 1-ийн дагуу);
 - 3.1.2 Иргэний үнэмлэхний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар эсхүл улсын бүртгэлийн лавлагаа;
 - 3.1.3 Тухайн албан тушаалд томилогдох хүсэлт, бурдүүлсэн материалын баталгааг илэрхийлсэн өргөдөл
 - 3.1.4 Тухайн иргэний мэргэжлийн мэдлэг, ур чадварын чадавхийг илэрхийлсэн 2 хүний тодорхойлолт;
 - 3.1.5 4 x 3-ийн хэмжээтэй 2 хувь цээж зураг;
 - 3.1.6 Нийгмийн эрүүл мэндийн болон анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, эрүүл мэндийн удирдлагаар мэргэшсэнийг нотлох баримт бичиг

/боловсролын диплом, мэргэшлийн үнэмлэхийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, эх хувийн хамт/;

3.1.7 Эрүүл мэндийн салбарт арваас доошгүй жил ажилласныг нотлох баримт /хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт/;

3.1.8 Эрүүл мэндийн байгууллагад таваас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан /хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын дэвтрийн холбогдох хэсгийг хуулбарлан эх хувийн хамт/;

3.1.9 Англи хэлний мэдлэг, чадвар дүгнэдэг "TOEIC" олон улсын шалгалтын гэрчилгээний хуулбар, эх хувийн хамт эсхүл гадаад хэлний мэдлэг чадварыг англи хэлээр суралцсан гадаад улсын их, дээд сургууль, коллеж төгссөн, магистр, докторын зэрэг хамгаалсан иргэний дипломыг үндэслэх ба мөн олон улсад хүлээн зөвшөөрөгддөг англи хэлний түвшин тогтоох шалгалт өгсөнийг гэрчлэх албан ёсны баримт бичиг /эх хувийн хамт/;

3.1.10 Тухайн эмнэлгийг хөгжүүлэх хөтөлбөрийн төсөл /тухайн эмнэлгийг бие даан хөгжүүлэхийн тулд бүтэц, зохион байгуулалт, хүний нөөц, санхүү, бодлого, төлөвлөлт, үйлчилгээний хувьд хэрхэн хөгжүүлэх, хэрхэн үр дүн, үр ашигтай ажиллуулах зэрэг/;

3.1.11 Улс төрийн намын гишүүн бус, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад удирдах албан тушаал эрхэлдэггүй, бусад байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагын бүрэлдэхүүнд хавсран ажилладаггүйг илэрхийлсэн баримт бичиг эсхүл тодорхойлолт

3.2 Энэ журмын 3.1-д заасан баримт бичгийг цаасаар мөн файл хэлбэрээр тус тусад нь дугтуйнд битүүмжлэн нарийн бичгийн даргад хүлээлгэн өгнө.

3.3 Төлөөлөн удирдах зөвлөл нь энэ журмын 3.1-д заасан баримт бичгийн бүрдлийг шалгаж, дутуу эсхүл хуурамч бүрдүүлсэн иргэнийг бүртгэхээс татгалзаж, энэ тухай өөрт нь мэдэгдэнэ.

3.4 Баримт бичгийн үнэлгээг доорхи шалгуураар үнэлнэ:

- 3.4.1 Боловсролын түвшин;
- 3.4.2 Туршлага;
- 3.4.3 Мэргэшсэн байдал;

Дөрөв. Ур чадварын үнэлгээ хийх

4.1 Ур чадварын үнэлгээг доорхи байдлаар үнэлнэ.

- 4.1.1 Сорилын шалгалт;
- 4.1.2 Бичгийн шалгалт;
- 4.1.3 Мэдээллийн технологийн мэдлэгийн түвшингийн ур чадварын шалгалт;
- 4.1.4 Гадаад хэлний мэдлэгийн түвшин тогтоох (ирүүлсэн материалыар үнэлнэ)
- 4.1.5 Ярилцлага нь 2 дэд хэсэгтэй байна.
 - 4.1.5.1 Тухайн эмнэлгийг хөгжүүлэх хөтөлбөр төслийн танилцуулга
 - 4.1.5.2 Бэлтгэсэн асуумжийн дагуу ярилцлага хийх.

4.2 Төлөөлөн удирдах зөвлөл нь дээр дурдсан шалгаруулалтад заасан шалгалтыг энэ журмын хоёрдуугаар хавсралт болох "Сонгон шалгаруулалтын үнэлгээ хийх заавар "-ын дагуу гүйцэтгэнэ.

Тав. Шалгарсан нэр дэвшигчийг эмнэлгийн захирлаар томилох

5.1 Төлөөлөн удирдах зөвлөл нь сонгон шалгаруулалтыг ажлын 5 хоногийн дотор явуулж, дүнг хуралдаанаар хэлэлцэн, тэмдэглэл хөтөлнө. Уг хуралдааны тэмдэглэлийг 3 хувь үйлдэж, дарга, гишүүд нарийн бичгийн дарга гарын үсэг зурж баталгаажуулна.

- 5.2 Сонгон шалгаруулалтын дүнг эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл шалгаруулалтанд тэнцсэн нэр дэвшигчдээс хамгийн өндөр оноо авсан нэр дэвшигчийг эмнэлгийн захирлын албан тушаалд томилох тухай тогтоолыг гаргана.
- 5.3 Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, эмнэлгийн захирлаар сонгогдсон нэр дэвшигчтэй Эмнэлгийн тусlamж үйлчилгээний тухай хуулийн 16.5; 16.7.1-д заасны дагуу гэрээ байгуулна.
- 5.4 Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь эмнэлгийн захирлын сонгон шалгаруулалтын дүнг олон нийтэд болон эрүүл мэндийн асуудал хариуцсан Төрийн захиргааны төв байгууллагад мэдээлнэ.
- 5.5 Сонгон шалгаруулалтанд шалгуур хангасан нэр дэвшигч тодроогүй тохиолдолд Эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөлөөс сонгон шалгаруулалтыг дахин явуулах тогтоол гарган ажлын З хоногт багтаан сонгон шалгаруулалтыг зарлана.

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 11 дүгээр сарын 06
өдрийн 14:50-т тушаалын
хөёрдугаар хавсралт

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ҮНЭЛГЭЭ ХИЙХ ЗААВАР

“Төрийн болон орон нутгийн өмчit төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах” журмын дагуу сонгон шалгаруулалтын үнэлгээг хийхдээ энэхүү зааврыг мөрдөнө.

Нэг. Шалгалтын хэлбэр, төрөл

1.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16.3-д заасан шаардлагыг баримтлан “Төрийн болон орон нутгийн өмчit төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн захирлыг сонгон шалгаруулах журам”ын 3.1 дэх хэсэгт заасан баримт бичгийн бүрдлийг хангасан иргэний материалд 3.4 дэх хэсэгт зааснаар үнэлгээ хийнэ.

1.1.1 Боловсролын түвшин;

1.1.2 Туршлага;

1.1.3 Мэргэшсэн байдал;

1.2. Сонгон шалгаруулах журмын 3.4 дэх хэсэгт заасан баримт бичгийн үнэлгээг хийгдсэн материалыг хоёрдох шатны шалгаруулалтад оруулна. Үүнд:

1.2.1 Сорилын шалгалт;

1.2.2 Бичгийн шалгалт;

1.2.3 Мэдээллийн технологийн мэдлэгийн түвшингийн ур чадварын шалгалт;

1.2.4 Ярилцлага нь 2 дэд хэсэгтэй байна.

1.2.4.1 Тухайн эмнэлгийг хөгжүүлэх хөтөлбөр төслийн танилцуулга

1.2.4.2 Бэлтгэсэн асуумжийн дагуу ярилцлага хийх.

1.3 Ур чадварын түвшин тогтоохдоо доорхи төрлийн шалгалт авна.

1.3.1. Эмнэлгийн захирлын албан тушаалд шаардагдах эрхзүйн болон удирдахуйн ухааны онол, арга зүйн мэдлэгийн сорилын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.3.2. Эмнэлгийн захирлын ажил, албан тушаалд бэлтгэгдсэн байдлыг үнэлэхтэй холбогдуулан авах бичгийн ур чадвар (эссэ, албан тоот, шийдвэрийн төсөл төлөвлөх гэх мэт)-ын шалгалтыг бичгийн хэлбэрээр зохион байгуулна.

1.3.3. Мэдээллийн технологийн мэдлэгийн түвшингийн ур чадварын шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.4. Тухайн байгууллагыг хөгжүүлэх хөтөлбөрийн төслийг иргэний танилцуулгаар сонсож үнэлнэ.

1.5 Урьдчилан бэлтгэсэн асуумж ашиглан зөвхөн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд иргэнтэй ганцаарчилсан ярилцлага хийнэ.

Хоёр. Шалгалтын хугацаа

2.1 Сонгон шалгаруулах ажлын хэсэг шалгалтын хэлбэр, төрөл, шалгалтад оролцогчдын тоо, шалгалт авах байрны боломж, мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, технологийн хангамж зэргийг харгалзан тухайн төрлийн шалгалтыг дараах аргуудаас сонгон авна. Үүнд:

- 2.1.1.Сорилын шалгалтыг зөвхөн цахим сүлжээ ашиглах, цахим сүлжээ ашиглах боломжгүй тохиолдолд сорил, сорилын хуудас (карт) бөглөх, хугацаа 40 минутаас хэтрэхгүй;
- 2.1.2.Бичгийн ур чадварын шалгалтыг эссэ, албан тоот, шийдвэрийн төсөл төлөвлөх, хугацаа 10 минутаас хэтрэхгүй;
- 2.1.3.Хөтөлбөрийн төслийн танилцуулга хийх хугацаа 8 минут, ярилцлагын хугацааг 5 минут өрсөлдөгч бүрт ижил хугацаатай байна.
- 2.1.4.Мэдээллийн технологийн мэдлэгийн шалгалтын хугацаа 15 минутаас хэтрэхгүй байна.

Гурав. Шалгалтын үнэлгээ

3.1 Энэхүү зааврын 1.2.1-д заасан ур чадварын түвшин тогтоо шалгалтад 40 хүртэл онооны үнэлгээ өгөх бөгөөд үүнээс энэхүү зааврын 1.3.1-1.3.3-т заасан шалгалтын төрөл тус бүрт дараах онооны үнэлгээ өгнө. Үүнд:

- 3.1.1. Эмнэлгийн захирлын албан тушаалд шаардагдах эрх зүйн болон удирдахуйн ухааны онол, арга зүйн мэдлэгийн шалгалтад 20 оноо хүртэл;
 - 3.1.2. Эмнэлгийн захирлын ажил, албан тушаалд бэлтгэгдсэн байдлыг үнэлэхтэй холбогдуулан авах бичгийн шалгалтад 10 оноо хүртэл;
 - 3.1.3.мэдээллийн технологийн мэдлэгийн түвшингийн шалгалтад 4 оноо хүртэл;
 - 3.1.4.гадаад хэлний мэдлэгийн түвшинг тогтоо 6 оноо хүртэл;
- 3.2. Энэхүү зааврын 1.3.1-д заасан сорилын шалгалт 40 асуулттай байх бөгөөд асуулт бүрт хариулах хугацаа 1 минут байна. Сорилын шалгалтын зөв хариулт бүрт 0.5 оноо ногдоно.
- 3.3. Энэхүү зааврын 1.4-т заасан хөтөлбөр, төслийн танилцуулгад 25 оноо хүртэл, 1.5-т заасан ярилцлагын үнэлгээнд 10 оноо хүртэл тус тус өгнө.
- 3.4. Энэхүү зааврын 1.1-т заасан тухайн албан тушаалд тавигдах ерөнхий шаардлагад нийт 25 хүртэл, үүнээс 1.1.1-1.1.3-т заасан шаардлага тус бүрт дор дурдсан оноо өгнө.
- 3.4.1.боловсролын түвшинд 7 оноо хүртэл;
 - 3.4.2.туршлагад 10 оноо хүртэл;
 - 3.4.3.мэргэшсэн байдалд 8 оноо хүртэл;
- 3.5 Энэхүү зааврын 1.1.3, 1.3.1-1.3.3, 1.4, 1.5-д заасан шалгалтын үнэлгээг дараах хүснэгтэд үзүүлсэн арга зүйн дагуу өгнө.

Үнэлгээний шатлал	Өгөх оноо				
	4 хүртэл оноо өгөх шалгалт	6 хүртэл оноо өгөх шалгалт	10 хүртэл оноо өгөх шалгалт	20 хүртэл оноо өгөх шалгалт	25 хүртэл оноо өгөх шалгалт
Машсайн	4	6	9-10	17-20	21-25
Сайн	3	4-5	7-8	12-16	15-20
Хангалттай	2	3	5-6	8-11	11-15
Дунд зэрэг	1	2	2-4	4-7	6-10
Хангалтгүй	0	1	0-1	0-3	0-5

3.6. Энэхүү зааврын 1.1.1-д заасан боловсролын түвшинд доорхи хүснэгтэд үзүүлсэн арга зүйн дагуу үнэлгээ өгнө.

Боловсролын зэрэг	Бакалаврын болон түүнтэй адилтгах боловсролын дипломын голч дүн	Магистр	Боловсролын доктор	Шинжлэх Ухааны доктор
Оноо	2.0-4.0	1	2	3

3.7 Дээд боловсролын дипломын голч дүнгээр 2.0-4.0 хүртэл оноо, боловсролын болон эрдмийн зэрэгт 1, 2, 3 гэсэн оноог өмнөх голч дүнгийн оноонд нэмж тооцно.

3.8 Энэхүү зааврын 1.1.2-д заасан туршлагыг үнэлэхдээ доорхи хүснэгтэд үзүүлсэн арга зүйн дагуу үнэлгээ өгнө.

Ажилласан жил	10-12 жил	13-15 жил	16-17 жил	18-20 жил	20-оос дээш
оноо	2 оноо	4 оноо	6 оноо	8 оноо	10 оноо

3.9 Иргэний мэргэшсэн байдлыг үнэлэхдээ их, дээд сургууль төгссөнөөс хойшхи хугацаанд мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан тухай гэрчилгээ, дипломоос гадна ажиллаж байсан туршлага үнэлэх илтгэх хуудастай танилцаж болно.

3.10 Энэхүү зааврын шалгалтын үнэлгээний нийт онооны дээд хязгаар 100 хүртэл байна. Хамгийн өндөр оноо авсан оролцогчийг шалгаруулна.

Дөрөв. Бусад асуудал

4.1 Энэхүү зааврын 3.10-д заасан нэгдсэн жагсаалтаар хамгийн өндөр үнэлгээ авч, нэр дэвшигдсэн сонгон шалгаруулалтад оролцогчийн их, дээд сургууль төгссөн дипломын хүчинтэй эсэх, магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын үзлэгийн дүгнэлт авах, Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлсэн, эсхүл бусад төрлийн гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгүүлээд ялгүйд тооцох буюу ялгүй болох хугацаа нь дуусаагүй тухай лавлагaa, Нийтийн албанад томилогдохоор нэр дэвшигдсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээн авч холбогдох байгууллагад хүргүүлэх зэрэг томилогдохын өмнөх бэлтгэлийг тухайн нэр дэвшигчийг томилох эрх бүхий төлөөлөн удирдах зөвлөл хариуцан бүрдүүлнэ.

4.2. Төлөөлөн удирдах зөвлөл нь сорилын болон ярилцлагын шалгалтын асуулт, бичгийн шалгалт болон даалгавар, тэдгээрийн хариулт (түлхүүр)-ыг боловсруулж бэлтгэх шатанд нууцлалыг хангаж ажиллана.

4.3 Энэхүү зааврын 4.2-т заасан нууцлалтай холбоотой асуудлыг хангаж ажиллаагүй ажилтан холбогдох хууль журмын дагуу хариуцлага хүлээнэ.

4.4. Сонгон шалгаруулалтын нарийн бичгийн дарга нь сонгон шалгаруулалтын үйл явцыг баримтжуулан албажуулж, тэдгээрийг төлөөлөн удирдах зөвлөлийн архивт зохих журмын дагуу хадгална.

4.5. Сонгон шалгаруулалтын дараа материалыг хуурамчаар бүрдүүлсэн ял шийтгэлтэй зэрэг хуульд заасан шаардлагыг хангаагүй асуудал үүсвэл сонгон шалгаруулалтыг хүчингүйд тооцон дахин зохион байгуулна.

4.6 Томилогдсон даргыг тухайн эмнэлгийн хамт олны өрдийн олонхоос дээш ирцтэй хуралд төлөөлөн удирдах зөвлөлөөс танилцуулах үйл ажиллагааг зохион байгуулна.

4.7. Энэхүү зааврыг нийтэд мэдээ

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 06 дугаар сарын 06.
өдрийн 14 тоот тушаалын
гуравдугаар хавсралт

ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮНГИЙН ХУУДАС

Оролцогчийн:

Зураг
4x3

.....(ургийн овог)

.....(эцэг,эхийн нэр)

.....(нэр)

.....(регистрийн дугаар)

Байгууллага:

Нэгж:

Албан тушаал:

Албан тушаалын:

ангилал: зэрэглэл:

Шалгалтын төрөл	Шалгалт өгсөн огноо	Авбал зохих оноо	Авсан оноо
1. Ерөнхий шаардлага (Боловсрол, туршлага, мэргэшсэн байдал)-ын оноо		25	
2. Удирдах ур чадвар (сорил, бичгийн болон мэдээллийн технологи)-ын оноо		40	
3. Хөтөлбөр, төслийн танилцуулга, ярилцлагын оноо		35	
НИЙТ ОНОО		100	

Дарга: / /
Нарийн бичгийн дарга: / /
Гишүүд:
/ /
/ /
/ /
/ /
/ /
/ /
/ /

20..... оны ... сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 11 дугаар сарын 06
өдрийн тоот тушаалын
дөрөвдүгээр хавсралт

**ЭМНЭЛГИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ НЭР ДЭВШИГЧИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ ШАЛГАЛТЫН НЭГДСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

№	Нэр дэвшигчийн нэр	Ерөнхий шаардлагын үнэлгээ /25 оноо/			Удирдах ур чадварын үнэлгээ /40 оноо/			Ярилцлага /35 оноо/			Нийт оноогоор эзлэх байр
		Боловсрол	Туршлага	Мэргэшсэн байдал	Сорилын шалгагт	Бичгийн шалгагт	Мэдээллийн технологи	Гадаад хэл	Хөтөлбөр, төсөл	Ярилцлага	
	Өгвөл зохих дээд оноо	7	10	8	20	10	4	6	25	10	100
1											
2											
3											

Дарга:

/

/

Нарийн бичгийн дарга:

/

/

Гишүүд:

/

/

/

/

/

/

/

/

/

/

20.... оны ... сарын ...-ны өдөр

Эрүүл мэндийн сайдын 2018
оны 11 дугаар сарын 06
өдрийн тоот тушаалын
тавдугаар хавсралт

TOEIC ШАЛГАЛТЫН ОНООГ БУСАД ШАЛГАЛТЫН ОНООТОЙ ХАРЬЦУУЛСАН ХҮСНЭГТ

TOEIC Оноо	Cambridge tests	ALTE	CEF	TOEFL IBT	IELTS	Олон улсын түвшинд	Ерөнхий чадамжууд	Мэдлэгийн түвшин
Дээд оноо 990	Дээд оноо CPE			Дээд оноо 120	Дээд оноо 9			
860-990	CAE/BEC Higher	5	C2	111-120	8.5-9	6	Ажил мэргэжилдээ шаардагдах стандарт англи хэлээр мэргэжлийнхээ хүрээнд ямар ч сэдвээр хэлэлцүүлэг, хурал, зөвлөгөө, маргаанд оролцох чадамжтай	Гүнзгай шат
730-859	FCE/BEC Vantage	4	C1	96-110	7.5-8	5	Сонсож, унших, бичих болон ярих чадамжуудыг зөв зохион байгуулалтай эзэмшсэн, мэргэжлийнхээ хүрээнд бүрэн ойлгож, харилцаанд ярианд чөлөөтэй оролцох чадамжтай	Дээд шат
470-729	PET/BEC Preliminary	3	B2	79-95	6.5-7	4	Мэддэг сэдвийнхээ хүрээнд харилцан ярианд чөлөөтэй оролцох, өдөр дутмын ажлаа мэргэжлийн түвшинд гүйцэтгэх хийж чадамжтай	Ахисан дунд шат
220-469	KET	2	B1	53-64	5-5.6			
				4.5-5	3	Ойлгох чадвар сайн ч өгүүлбэрийн	Дунд шат	

				41-52	4		болон дүрмийн бүтэц дээр алдаа гаргаж харилцан ярианд оролцдог тул ажлын байранд, мэргэжлийн түвшинд хязгаарлагдмал чадамжтай	
0-219	1	A2	30-40	3-3.5	2	Угийн сангийн баялаг хязгаарлагдмал тул буруу ойлгох бэрхшээлтэй ч, үргэлжилсэн ярианы ойролцоо утгыг гаргаж, мэддэг сэдвийнхээ хүрээнд нийгмийн харилцаанд бусдын дэмжлэгтэй оролцох чадамжтай	Ахисан анхан шат	
			19-29	2-2.5				
		A1	9 18	1-1.5	1	Цээжилж тогтоосон уг хэллэгийнхээ хүрээнд зөвхөн энгийн бүтэцтэй богино өгүүлбэрээр өөрийгөө илэрхийлэх чадамжтай	Анхан шат	

Эрүүл мэндийн сайдын 2018
оны ... дүгээр сарын 26.
өдрийн ... тоот тушаалын
зургаадугаар хавсралт

**ТУХАЙН АЛБАН ТУШААЛД ТОМИЛОГДОХ ХҮСЭЛТ,
БҮРДҮҮЛСЭН МАТЕРИАЛЫН БАТАЛГААГ
ИЛЭРХИЙЛСЭН ӨРГӨДЛИЙН ХУУДАС**

.....(ургийн овог)

.....(эцэг,эхийн нэр)

.....(нэр)

.....(регистрийн дугаар)

Утга: 1. Ирүүлсэн материал үнэн бодит байдлыг бүрэн хариуцахаа илэрхийлэн бичих;
2. Ирүүлсэн материалыг товч дурьдаж хуудсыг тодорхой заасан байх;
3. Энэ ажлыг эрхлэх хүсэлтээ илэрхийлсэн байх;

.....
.....
.....
.....
.....
.....
.....
.....

Гарын үсэг:

/

/

20.... оны ... сарын ...-ны өдөр